



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/232

Булган сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төслүүдийг боловсруулж, эрэмбэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Г.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын дарга)

Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг сум, агентлагуудаас хуулийн хугацаанд авч, төлөвлөлтийг хууль журмын дагуу боловсруулж, эрэмбэлэн Сангийн яам болон холбогдох яамнуудад хуулийн хугацаанд хүргүүлэхийг ажлын хэсэг (Г.Давааням)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Булган Аймаг 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

0323010208